


## МӨНГӨНИЙ ТОЙМ

(2016 оны 1 дүгээр сар)



## МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


	2014		2015					2016
	12-р сар	1-р сар	3-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	1-р сар
<b>М2 мөнгө, тэрбум төгрөгөөр</b>	10,635.8	10,314.6	9,903.7	9,934.5	9,900.3	9,809.3	10,050.2	9,850.8
сарын өөрчлөлт, %	7.1	-3.0	-3.2	-0.3	-0.3	-0.9	2.5	-2.0
жилийн өөрчлөлт, %	12.5	2.9	-0.5	-1.4	-0.7	-1.2	-5.5	-4.5
<b>Бусад хадгаламж, тэрбум төгрөгөөр</b>	8,819.1	8,735.6	8,457.6	8,320.9	8,269.5	8,246.5	8,364.8	8,242.7
сарын өөрчлөлт, %	7.0	-0.9	-2.2	0.5	-0.6	-0.3	1.4	-1.5
жилийн өөрчлөлт, %	19.8	8.4	3.0	1.0	0.6	0.1	-5.2	-5.6
<b>Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр</b>	809.7	732.4	702.8	767.9	739.7	710.5	706.7	713.8
сарын өөрчлөлт, %	5.3	-9.5	-9.4	-0.8	-3.7	-3.9	-0.5	1.0
жилийн өөрчлөлт, %	-3.7	-18.1	-12.3	-7.2	-8.6	-7.6	-12.7	-2.5
<b>Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр</b>	3,426.5	2,858.7	2,468.5	2,410.1	2,192.2	2,087.0	2,459.6	2,310.7
сарын өөрчлөлт, %	27.9	-16.6	-10.2	-14.7	-9.0	-4.8	17.9	-6.1
жилийн өөрчлөлт, %	2.7	-3.3	-21.1	-14.7	-19.0	-22.1	-28.2	-19.2
<b>Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮</b>	16,604.7	16,336.0	17,074.2	17,829.8	17,879.1	17,847.7	17,944.0	18,085.9
сарын өөрчлөлт, %	2.7	-1.6	3.2	1.2	0.3	-0.2	0.5	0.8
жилийн өөрчлөлт, %	31.9	26.2	22.9	12.2	10.1	10.4	8.1	10.7
<b>Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮</b>	12,502.5	12,088.8	12,271.4	11,938.5	11,910.1	11,889.3	11,695.8	11,783.0
сарын өөрчлөлт, %	-1.2	-3.3	0.8	0.8	-0.2	-0.2	-1.6	0.7
жилийн өөрчлөлт, %	16.1	9.8	7.8	-5.3	-7.2	-6.0	-6.5	-2.5
<b>Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, хувиар</b>	5.00	5.44	5.73	7.14	7.32	7.28	7.44	7.59
<b>Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, хувиар (Хадгаламж, Зоос банкныг хассанаар)</b>	3.10	3.51	3.90	5.25	5.43	5.39	5.53	5.69
<b>Хүү</b>								
Хадгаламжийн ЖДХ	12.5	12.7	12.9	13.1	13.3	13.3	13.3	13.5
Зээлийн ЖДХ*	19.5	20.0	19.1	18.7	20.0	19.5	19.1	19.7
Монголбанкны ҮТХ зээлийг оруулсан ЖДХ*	16.9	16.9	17.6	17.6	18.6	18.5	18.3	19.1
Ипотекийн зээлийн ЖДХ	9.9	10.2	9.2	9.6	9.4	10.0	8.8	10.0
ТБҮЦ-ны ЖДХ	12.1	12.3	13.1	13.0	13.0	13.0	13.0	12.6
Бодлогын хүү	12.0	13.0	13.0	13.0	13.0	13.0	13.0	12.0
БХЗ-ын ЖДХ	12.2	12.6	13.2	13.1	13.4	11.8	11.8	11.8
<b>Инфляци</b>								
<b>Улаанбаатар хотын инфляци</b>								
сарын	0.6	0.5	0.8	-0.9	-1.1	0.6	-0.2	0.4
оны эхнээс	10.7	0.5	1.5	1.9	0.8	1.3	1.1	0.4
жилийн	10.7	9.3	8.8	3.9	1.9	1.9	1.1	1.0
<b>Суурь инфляци</b>								
сарын	0.4	0.4	0.1	0.3	0.3	1.3	-0.1	-0.4
оны эхнээс	12.6	0.4	0.5	3.2	3.5	4.9	4.8	-0.4
жилийн	12.6	12.3	11.9	6.1	4.8	5.3	4.8	4.0
<b>Улсын инфляци</b>								
сарын	0.8	0.7	0.8	-0.8	-0.7	0.2	-0.2	0.5
оны эхнээс	11.0	0.7	1.9	2.6	1.9	2.1	1.9	0.5
жилийн	11.0	9.8	9.3	4.9	3.4	2.9	1.9	1.7

\* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

## Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 2.0 хувиар, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурч 9850.8 тэрбум төгрөг болжээ.


Мөнгөний нийлүүлэлтийн 53.9 хувийг төгрөгийн хадгаламж, 20.1 хувийг гадаад валютын хадгаламж, 11.4 хувийг төгрөгийн харилцах, 9.6 хувийг гадаад валютын харилцах, 4.9 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.



Тайлант сард гадаад валютын харилцахын жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сарынхаас 12.2 нэгж хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 12.0 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 7.9 нэгж хувь тус тус өссөн бол гадаад валютын хадгаламжийнх 8.6 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 1.4 хувиар хувиар буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл төгрөгийн хадгаламж 121.5 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 105.4 тэрбум төгрөг, гадаад валютын харилцах 36.3

тэрбум төгрөгөөр буурч, гадаад валютын хадгаламж 35.7 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 28.1 тэрбум төгрөгөөр өсчээ.



Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурсны 0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 0.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, -0.5 нэгж хувийг гадаад төгрөгийн хадгаламж, -2.0 нэгж хувийг валютын хадгаламж, -2.2 нэгж хувийг валютын харилцах тус тус бүрдүүлсэн байна.


## Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 1.2 хувь буюу 85.8 тэрбум төгрөгөөр буурч 7297.3 тэрбум төгрөг болов.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 6.1 хувь буюу 63.9 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 37.5 хувь буюу 587.1 тэрбум төгрөгөөр буурч 980.5 тэрбум төгрөгт болжээ. Иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 1.3 хувь буюу 57.7 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 14.1 хувь буюу 535.0 тэрбум төгрөгөөр өсч 4332.0 тэрбум төгрөгт хүрчээ.

Нийт хадгаламжийн 72.8 хувь нь төгрөгийн, 27.2 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар өссөн байна.




Мөнгөний нийлүүлэлтийн 11.4 хувийг эзэлж буй төгрөгийн харилцах өмнөх сараас 8.6 хувь буюу 105.4 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.0 хувь буюу 11.1 тэрбум төгрөгөөр өсч 1121.3 тэрбум төгрөгт хүрсэн бол 9.6 хувийг эзэлж буй валютын харилцах өмнөх сараас 3.7 хувь буюу 36.3 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 19.6 хувь буюу 229.8 тэрбум төгрөгөөр буурч 945.4 тэрбум төгрөг болжээ.

Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 1.8 хувь буюу 35.7 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 9.6 хувь буюу 211.0 тэрбум төгрөгөөр буурч 1984.8 тэрбум төгрөг болжээ.

### Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх сараас 7.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.0 дахин буурснаар -4216.3 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив өмнөх сараас 8.3 хувь, өмнөх оны мөн үеэс 31.1 хувиар буурч 5634.5 тэрбум төгрөг болов.




банкуудын кассын эзлэх хувь 0.6 нэгж хувиар өсч 9.7 хувьтай байна.

**Зээл**

Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сараас 2.6 нэгж хувиар өсч өмнөх оны мөн үеэс 15.4 нэгж хувиар буурч жилийн 10.7 хувийн өөрчлөлттэй байна.

**Нөөц мөнгө**

Нөөц мөнгө өмнөх сараас 6.1 хувь, өмнөх оны мөн үеэс мөн 19.2 хувиар буурч 2310.7 тэрбум төгрөг болжээ. Тайлант сард Төв банк дахь харилцах, хадгаламж 8.9 хувь буюу 155.9 тэрбум төгрөг, банкуудын касс 8.6 хувь буюу 21.0 тэрбум төгрөгөөр буурсан бол хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 6.1 хувь буюу 28.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл өмнөх сарынхаас 0.8 хувь буюу 141.9 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 9.7 хувь буюу 1749.9 тэрбум төгрөгөөр өсч 18.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүний 65.2 хувь буюу 11.8 их наяд төгрөгийн зээлийг хадгаламжийн байгууллагуудын, 34.8 хувь буюу 6.3 их наяд төгрөгийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл бүрдүүлж байна.

Санхүүгийн байгууллагуудаас иргэдэд олгосон зээл өмнөх сараас 1.4 хувь буюу 96.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 13.3 хувь буюу 951.6 тэрбум төгрөгөөр өсч 7140.4 тэрбум төгрөгт, хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 0.4 хувь буюу 27.2 тэрбум төгрөгөөр буурч өнгөрсөн оны мөн үеэс 0.2 хувь буюу 14.0 тэрбум төгрөгөөр өсч 7051.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар буурч 69.2 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 4.7 нэгж хувиар өсч 21.1 хувь,



Санхүүгийн байгууллагуудын нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 39.5 хувь нь иргэд, 39.0 хувь нь хувийн хэвшил, 21.5 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.



Нийт зээлийн үлдэгдлийн 87.0 хувийг хэвийн зээл, 8.1 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 4.9 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 5.1 нэгж хувь, чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.9 нэгж хувиар өссөн байна.


Хадгаламжийн байгууллагуудын зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 7.6 хувь байгаа

бөгөөд татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 5.7 хувийг эзэлж байна.

## Картын зээл

Банкуудаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон картын зээлийн үлдэгдэл нийт банкны салбарын зээлийн үлдэгдлийн 1.9 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл 1 дүгээр сарын байдлаар 220.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар буюу 37.2 тэрбум төгрөгөөр буурчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд өмнөх сараас 0.1 хувиар буюу 0.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.




Картын зээлийн 91.2 хувь нь хэвийн, 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 6.4 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 92.9 хувь нь төгрөгөөр, 7.1 хувь нь валютаар олгогдсон байна.

## Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2016 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсч жилийн 12.6 хувь болов.

Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурч жилийн 19.7<sup>1</sup> хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар буурч жилийн 12.3 хувь болжээ.




Төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 0.2 нэгж хувиар өсч жилийн 3.1 хувь, валютынх мөн 0.2 нэгж хувиар өсч жилийн 1.6 хувьд хүрчээ. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өсч жилийн 13.5 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өсч жилийн 6.7 хувь болов.

### Мөнгөний зах

2016 оны 1 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 776.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 11.8 хувь байна.

<sup>1</sup> Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин ҮТХ-ийн зээлийг оруулан тооцвол



2016 оны 1 сарын 6-ны өдрөөс 2016 оны 2 сарын 2-ны өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 942.6 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд дунджаар 419.5 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 903.9 тэрбум төгрөг, валютын нөөцөд дунджаар 652.8 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

### Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2016 оны 1 дүгээр сарын эцэст 2011.38 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 66.6 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2003.2 төгрөг байв.

Тайлант сарын эцэст төгрөгийн евроотой харьцах ханш 2192.1, хятадын юаньтай харьцах ханш 305.9, японы иентэй харьцах ханш 16.7 төгрөг болжээ.

төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 19.1 хувь байна.

## Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2016 оны 1 дүгээр сарын эцэст өмнөх сараас 0.5 хувь, өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар өссөн бол Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.4 хувь, өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар өсчээ. Суурь инфляци тухайн сард 0.4 хувиар буурсан ч жилийн 4.0 хувьтай байв.

**Тухайн сард** мах, махан бүтээгдэхүүний үнэ 8.3 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 0.4 хувь өсч жимсний үнэ 0.5 хувиар буурснаар хүнсний барааны бүлгийн үнэ 2.7 хувиар өссөн байна. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.4 хувиар буурсан нь нүүрсний үнэ 5.9 хувь, дизель, бензиний үнэ 4.8-5.2 хувиар буурсантай холбоотой. Харин гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы үнэ 5.9 хувиар өссөн байна.

Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 55 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 29 бараа үйлчилгээнийх буурсан байна.



Боловсролын бүлгийн **жилийн инфляци** 23.6 хувь (*жилийн өсөлтийн 169.0 хувь*), эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийнх 6.0 хувь (*жилийн өсөлтийн 17.1 хувь*), гэр ахуйн тавилга, барааны бүлгийнх 5.4 хувь (*жилийн өсөлтийн 16.9 хувь*), зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны

үйлчилгээний бүлгийнх 3.5 хувь (*жилийн өсөлтийн 11.9 хувь*), хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 2.1 хувь (*жилийн өсөлтийн 26.0 хувь*), орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 1.6 хувиар (*жилийн өсөлтийн 22.8 хувь*) тус тус өссөн байна. Харин хүнсний барааны үнэ 5.4 хувь (*жилийн өсөлтийн -155.3 хувь*), тээврийн бүлгийн үнэ 2.5 хувь (*жилийн өсөлтийн -26.9 хувь*), холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 0.8 хувиар (*жилийн өсөлтийн -2.0 хувь*) буурсан байна.

Хүнсний барааны бүлгийг задалж үзвэл, 0.4 нэгж хувийг талх, гурил, будаа, 0.1 нэгж хувийг хүнсний ногоо, 0.1 нэгж хувийг өөх, тос, -0.4 нэгж хувийг сүү, өндөг, -2.0 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт бүрдүүлсэн байна.